-1-

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 02 өдөр Дугаар А/01 Дуурсах

Цагдаагийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 54 дугаар зүйлийн 54.1 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх хэсэг, Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г” дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2020 онд дэвшүүлсэн зорилтын шалгуур үзүүлэлтийн төлөвлөгөөг нэгдүгээр, Цагдаагийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус батлалсугай.

2. Цагдаагийн ерөнхий газраас дэвшүүлсэн зорилтыг алба хаагчдад сурталчлан таниулах, цагдаагийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан хариуцсан тасаг, алба хаагчдынхаа 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлт, үр дүнг тооцож ажиллахыг тасгийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190541

-54-

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 02 өдөр Дугаар А/02 Дуурсах

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Байгууллагын даргын тушаал гаргах " журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г" дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн газрын 2020 онд батлагдсан үйл ажиллагааны зардлын төсвөөс бичиг хэрэг, урсгал засварын бараа материал, хоол хүнс нийлүүлэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: О.Сувд-Эрдэнэ-Ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч

Нарийн бичгийн дарга: Б.Пүрэвсүрэн-Аж ахуйн ажилтан, цагдаагийн дэслэгч

Гишүүд:

Б.Даваацэрэн-Нягтлан бодогч, цагдаагийн дэслэгч

Т.Ерэнбаяр-Эдийн засгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад

Н.Батсайхан-Иргэний зөвлөлийн гишүүн /тохиролцсоноор/

2. Техникийн тодорхойлолт бэлтгэх, үнийн санал ирүүлэх урилга, баримт бичгийг боловсруулах, үнийн санал хүлээн авах, нээх ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан эрх, үүргийн дагуу зохион байгуулан ажиллахыг ажлын хэсгийн дарга /Цагдаагийн хошууч, О.Сувд-Эрдэнэ/-д даалгасугай.

3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /Цагдаагийн дэд хурандаа, Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

20190343

-55-

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 01 сарын 02 өдөр Дугаар А/03 Дуурсах

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Байгууллагын даргын тушаал гаргах ” журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г” дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн газрын 2020 онд батлагдсан үйл ажиллагааны зардлын төсвөөс тээвэр, шатахуун нийлүүлэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: О.Сувд-Эрдэнэ-Ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч

Нарийн бичгийн дарга: Б.Пүрэвсүрэн-Аж ахуйн ажилтан, цагдаагийн дэслэгч

Гишүүд:

Б.Даваацэрэн-Нягтлан бодогч, цагдаагийн дэслэгч

Т.Ерэнбаяр-Эдийн засгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад

Н.Батсайхан-Иргэний зөвлөлийн гишүүн /тохиролцсноор/

2. Техникийн тодорхойлолт бэлтгэх, үнийн санал ирүүлэх урилга, баримт бичгийг боловсруулах, үнийн санал хүлээн авах, нээх ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан эрх, үүргийн дагуу зохион байгуулан ажиллахыг ажлын хэсгийн дарга /Цагдаагийн хошууч, О.Сувд-Эрдэнэ/-д даалгасугай.

3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /Цагдаагийн дэд хурандаа, Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

20130545

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2020 оны 01 сарын 06 өдөр Дугаар А/04 Дуурсах

Баг хариуцуулах тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”-д дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг шуурхай хүртээмжтэй хүргэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хуулиар харъяаллуулсан захиргааны зарим үүргийг гүйцэтгэх, ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор Баянхонгор сумын 10 багийг хавсралтад зааснаар хэсгийн байцаагч нарт хуваарилан хариуцуулсугай.

2. Хариуцсан багийн обьектын судалгааг шинэчлэн гаргаж, гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг чанар үр дүнтэй зохион байгуулж, иргэдэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг шуурхай, хүртээмжтэй хүргэж, “Цагдаагийн ажил, үйлчилгээний стандарт”-ыг мөрдлөг болгон ажиллахыг хэсгийн байцаагч нарт, баг хариуцсан хэсгийн байцаагч нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Мөнгөнтулга/-д тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргалд /-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190553

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2020 оны 01 сарын 06 өдөр Дугаар А/05 Дуурсах

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г", Аймгийн засаг даргын 2020 оны А/01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архидан согтуурахтай тэмцэх жилийн аяныг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Мөнгөнтулга-Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

Нарийн бичгийн дарга: М.Баянзул-Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад

Гишүүд:

Ж.Наранбаатар- Хэрэг бүртгэх тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн дэд хурандаа

П.Дэлгэржав- Мөрдөн байцаах тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад

А.Батхуяг- Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч

Г.Анхбаяр- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч

Д.Хоролгарав- Сэтгэл зүйч, цагдаагийн дэслэгч

Л.Мөнхзаяа- Нийтийн хэв журам хамгаалах тасгийн багийн цагдаа, цагдаагийн ахлагч

2. Дээрх ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, дүнг илтгэх хуудсаар танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Мөнгөнтулга/-д үүрэг болгосугай.

(D)-Alban bichig-Tushaal-2019

20130555

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга / цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

-60-

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2020 оны 01 сарын 06 өдөр    Дугаар А/06    Дуурсах

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код136/ -ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ыг "г" заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Алба хаагчдын мэдлэг боловсрол, ажлын ур чадварыг дээшлүүлэх, Төрийн жинхэнэ алба хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, хөрөнгө орлогын мэдүүлгийг бөглүүлэх зорилгоор "Хэсгийн төлөөлөгч нарын сургалт"-ыг 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр хүртэл хоёр хоногийн хугацаанд зохион явуулсугай.

2. Сургалтанд оролцох алба хаагч нарын нэрсийг нэгдүгээр, сургалтын хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтын үед шаардагдах зардлын тооцоо судалгааг гарган батлуулж, зохих журмын дагуу холбогдох зардал гаргахыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Сургалтыг хөтөлбөрийн дагуу үр дүнтэй зохион байгуулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа П.Пүрэвдорж/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА    Ц.АНХБАЯР



20190557

-63-

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 08 өдөр Дугаар А/07 Дуурсах

Алба хаагчдын удаан жил, цол,
онцгой албаны нэмэгдлийг
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.9, 87.10 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 3, 9 дүгээр хавсралт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоох" журам /код 924/-ын 924.43а, б, 61а, б, в, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дах хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Алба хаагчдын төрийн тусгай алба хаасны удаан жил, цол, онцгой албаны нэмэгдлүүдийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс шинэчлэн тогтоож баталсугай.

2. Алба хаагчдын төрийн тусгай алба хаасны удаан жил, цол, онцгой албаны нэмэгдлийг хавсралтаар баталсугай.

3. Алба хаагчдын төрийн тусгай алба хаасны удаан жил, цол, онцгой албаны нэмэгдлийг хавсралтад заасан хугацааны дагуу бодож, олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190559

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 09 өдөр Дугаар А/08 Дуурсах

Шуурхай штабын бүрэлдэхүүн,
штабын ажиллах чиг үүргийг
шинэчлэн батлах тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/78 дугаар тушаал, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Шуурхай удирдлагын үйл ажиллагаа" журам /код 200/-ын 200.6.17 дахь хэсгийн 200.6.17-ын "д", "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Аймгийн хэмжээнд онцгой нөхцөл байдлын болон нөхцөл байдал хүндэрсэн үед ажиллах шуурхай штабын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шуурхай удирдлагын штабын бүлгүүдийн алба хаагчдын нэрсийг хоёрдугаар хавсралтаар батлсугай.

2. Онцгой нөхцөл байдлын болон нөхцөл байдал хүндэрсэн үед гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан бие бүрэлдэхүүний албаны бэлэн байдлыг хангуулж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Шуурхай удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаярт/-д үүрэг болгосугай.

3. Онцгой нөхцөл байдлын болон нөхцөл байдал хүндэрсэн үед хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Мөнгөнтулга/, Замын цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Д.Ууганбаяр/-д нарт үүрэг болгосугай.

4. Онцгой нөхцөл байдлын болон нөхцөл байдал хүндэрсэн үеийг далимдуулан үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, нөхцөл байдлын талаар мэдээ, мэдээлэл цуглуулж, үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, иргэд, байгууллагаас

ирүүлсэн гомдол, мэдээлэл бүрийг хүлээн авч, шалгаж шийдвэрлэх талаар удирдлагын хяналтыг чиглүүлж, үр дүнг тооцож, тухай бүр танилцуулан ажиллахыг Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа П.Пүрэвдорж/-д, Мөрдөн байцаах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Г.Батаа/, Хэрэг бүртгэх тасгийн дарга /цагдаагийн хошууч О.Чулуунбат/-д нарт тус тус үүрэг болгосугай.

5. Шуурхай штабыг байгуулах, шаардлагатай техник хэрэгслийг бэлтгэх, холбогдох хууль, журам, тушаалын төсөл боловсруулах, удирдлагыг мэдээллээр хангах, нөхцөл байдлын танилцуулга бэлтгэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга, /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/, Шуурхай удирдлагын тасгийн дарга /цагдаагийн хошууч С.Ариунбаяр/-д даалгасугай.

6. Тушаалыг штабын гишүүдэд уншиж танилцуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргалд/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 09 өдөр Дугаар А/09 Дуурсах

Алба хаагчдад баг хариуцуулан ажиллуулах тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.1.4, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”, Мөн даргын 2019 оны А/200 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Дүн шинжилгээ, судалгаа хийх” журам /код 721/-ын 721.7 дахь хэсгийн 721.7.2-ын “г”-д дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, тасаг, албадын уялдаа холбоог сайжруулах зорилгоор эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч нарт баг хариуцуулан ажиллуулсугай.

2. Баг хариуцуулах эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, хэсгийн байцаагч нарын хуваарийг нэгдүгээр, Сум дундын цагдаагийн тасгийн дарга, мөрдөгч, хэсгийн төлөөлөгч нарт сум хариуцуулах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хариуцсан багтаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сар бүр нэгээс доошгүй ажил, арга хэмжээг зохион байгуулж, дүнг сар бүрийн 25-ны дотор дүн шинжилгээ судалгааны багт ирүүлэх, хариуцсан багийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн эзэнгүй гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж, ажиллахыг баг хариуцсан эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, хэсгийн байцаагч нарт үүрэг болгосугай.

4. Баг хариуцсан алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж, үр дүнг улирал бүр тооцон Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч П.Пүрэвдорж/-д үүрэг болгосугай.



- 20190565

5. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргалд /-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2020 оны 01 сарын 15 өдөр          Дугаар А/10          Дуурсах

"Ёс зүйн зөвлөл"-ийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга, ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлэх, сэтгэлгээний хандлагыг өөрчлөх зорилгоор орон тооны бус "Ёс зүйн зөвлөл"-ийг шинэчлэн байгуулсугай.

2. Хамт олны санал, гаргасан шийдвэрээр томилогдсон "Ёс зүйн зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Алба хаагчдын сахилга, ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлэх, сэтгэлгээ хандлагыг өөрчлөх чиглэлээр үр дүнтэй, шинэлэг ажил, арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг "Ёс зүйн зөвлөл"-ийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/01 дүгээр тушаалыг хүчингүй болгосугай.

5.Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА          Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190567

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 17 өдөр Дугаар А/11 Дуурсах

Сургалт зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны Б/105 дугаар тушаал, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын даргын тушаал гаргах /код-136/ журам"-ын 136-ын 136.5.2-ын "г" дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах, аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр төлөвлөгөө"-ний дагуу сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Баянхонгор аймгийн Эрдэнэцогт суманд зохион байгуулсугай.

2. Сургалтанд хамрагдах нэр бүхий иргэдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Сургалтыг батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу үр дүнтэй зохион байгуулж, дүнг танилцуулахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Мөнгөнтулга/-т үүрэг болгосугай.

4. Сургалтад шаардагдах зардлыг зохих журмын дагуу зарцуулахыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 17 өдөр Дугаар А/12 Дуурсах

Буудлагын дадлага, сургалт
зохион байгуулах тухай

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын даргын тушаал гаргах журам /код-136/"-ын 136.5.2-ын "г", Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/208 дугаар тушаалаар батлагдсан "Галт зэвсэг хадгалах, хамгаалах, бүртгэх, биедээ авч явах, олгох" журам" /код-235/-ын 235.12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэдэд зориулсан галт зэвсгийн буудлагын дадлага олгох сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр Баянхонгор сумын Эрдэнэцогт сумын урд байрлах буудлагын сургалтын талбайд зохион байгуулсугай.

2. Буудлагын ахлах удирдагчаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч /цагдаагийн ахлах дэслэгч А.Алтантогоо/, саатуулах байрны эмч /цагдаагийн ахлах дэслэгч Ю.Мөнхжин/ нарыг тус тус томилсугай.

3. Буудлагын үеийн аюулгүй арга хэмжээний дүрэм, зааврыг чанд мөрдөж, аюулгүй байдлыг ханган, сургалт зохион байгуулж, дүнг танилцуулахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Мөнгөнтулга/-т үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20200005

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 17 өдөр Дугаар А/13 Дуурсах

Шалгалтын комисс байгуулах тухай

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын даргын тушаал гаргах /код-136/ журам"-ын 136.5.2-ын "г", Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/72 дугаар Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах, аюулгүй ажиллагааны сургалтын зааврын 3.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах, аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан иргэн, ажилтнаас хууль эрх зүйн болон ур чадварын шалгалтыг авах комиссыг доорх албан тушаалын бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Шалгалтын комиссын дарга:

Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Мөнгөнтулга

Шалгалтын комиссын нарийн бичгийн дарга:

Цагдаагийн ахлах дэслэгч А.Алтантогоо

Шалгалтын комиссын гишүүн:

Цагдаагийн ахлах дэслэгч Ю.Мөнхжин

Шалгалтын комиссын гишүүн:

Цагдаагийн ахлах дэслэгч М.Бямбадорж

Шалгалтын комиссын гишүүн:

Цагдаагийн ахлагч Б.Бямбажаргал

Шалгалтын комиссын гишүүн:

Цагдаагийн дэд ахлагч Э.Даваацэрэн

2. Сургалтын төлөвлөгөөнд заасан чиглэлээр суралцагчдаас төгсөлтийн шалгалт авч, мэдлэг, ур чадварыг бодитой үнэлж, дүнг танилцуулахыг шалгалтын комиссын дарга /Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хошууч Б.Мөнгөнтулга/-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /Цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал /-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 17 өдөр Дугаар А/14 Дуурсах

Гэрчилгээ олгох тухай

Галт зэвсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/72 дугаар тушаалаар батлагдсан "Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах, аюулгүй ажиллагааны сургалтын заавар"-ын 3.4.2, 3.4.3 дахь заалт, мөн зааврын 3.7.2 дахь хэсэг, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баянхонгор аймгийн Эрдэнэцогт суманд Иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах, аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж, шалгалтад амжилттай дүн үзүүлсэн иргэдэд гэрчилгээ олгосугай.

2. Сургалтын гэрчилгээ авах иргэдийн нэрс, бүртгэлийн дугаарыг хавсралтаар батлсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал /-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20200007

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 17 өдөр Дугаар А/15 Дуурсах

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ятгах тусам нягтал аяныг эрчимжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Батаа-Мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

Нарийн бичгийн дарга: М.Баянзул-Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад

Гишүүд:

Ж.Наранбаатар- Хэрэг бүртгэх тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн дэд хурандаа

Г.Алтанбагана- Эрүүгийн цагдаагийн тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч

А.Батхуяг- Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч

Г.Анхбаяр- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч

А.Алтантогоо-Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч

В.Ганзориг- Шуурхай удирдлагын тасгийн жижүүрийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч

2. Дээрх ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, дүнг илтгэх хуудсаар танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч Мөрдөн байцаах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Г.Батаа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга / цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2020 оны 01 сарын 24 өдөр Дугаар А/16 Дуурсах

Ажил хүлээлцүүлэх ажлын хэсэг
байгуулах тухай

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г", Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны Б/53, 59, 68 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны Б/53 дугаар тушаалаар цагдаагийн хошууч Б.Бямбааг Шуурхай удирдлагын тасгийн мэдээлэл, судалгааны ахлах мэргэжилтэнээр мөн даргын 2020 оны Б/59 дүгээр тушаалаар цагдаагийн ахлах дэслэгч Б.Алтангадасыг экологийн асуудал хариуцсан эрүүгийн мөрдөгчөөр, цагдаагийн ахмад М.Дамдиндоржийг экологийн асуудал хариуцсан мөрдөгчөөр, цагдаагийн дэслэгч С.Дашбалбарыг Баян-Овоо сум дахь экологийн асуудал хариуцсан байцаагчаар мөн даргын 2020 оны Б/68 дугаар тушаалаар цагдаагийн дэслэгч П.Мөнхтэгшнямыг Заг сум дахь хэсгийн төлөөлөгчөөр тус тус томилогдсонтой холбогдуулан ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: П.Пүрэвдорж-Дэд бөгөөд эрүүгин цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

Гишүүд: Г.Батаа- Мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

С.Ариунбаяр-Шуурхай удирдлагын тасгийн дарга, цагдаагийн хошууч

Г.Алтанбагана-Эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч

Н.Элбэгсайхан- Нярав, цагдаагийн дэд ахлагч

2. Дээрх албан тушаал /ажлын байр/-д томилогдсон алба хаагчийн ажлыг хүлээлцүүлж, дүнг илтгэх хуудсаар танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч Дэд бөгөөд эрүүгин цагдаагийн тасгийн дарга, /цагдаагийн дэд хурандаа П.Пүрэвдорж/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2020

20200027